

“Архигүй Булган” хөтөлбөр
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх заалт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 75 дах заалтыг үндэслэн аймгийн 6 дах удаагийн сонгуулийн 3 дугаар Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1.”Архигүй Булган” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.”Архигүй Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нэгдсэн эмнэлэгийн сэтгэц наркологиын тасгийн орыг нэмэгдүүлж, боловсон хүчний хангамжийг сайжруулах арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга Д.Эрдэнэбатад даалгасугай.

3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, биелэлт үр дүнг хагас бүтэн жилээр тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга/Д.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

М.ОЮУНБАТ

“АРХИГҮЙ БУЛГАН” ХӨТӨЛБӨР

НЭГ.ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн эрүү хэв журмын нөхцөл, хүн амын эрүүл мэндийн байдалд үндэслэн боловсруулав.

Аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг сүүлийн жилдөсөж хүний амийг санаатай хохироосон гэмт хэргийн 53,3 хувь нь согтуугаар, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 40 хувь нь согтуугаар, золгүй байдлаар нас баралт болон өөрийн амь насыг хохироосон хэргийн 80 гаруй хувь нь согтуугаар үйлдэгдэж байна.

Архидан согтуурсан гэмт хэргийн 67 хувь нь гэр бүл, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа нь гэр бүлийн хүчирхийллийн үндсэн шалтгаан болж, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настнуудын эрүүл аюулгүй орчинд тайван амьдрах нөхцөл бололцоог алдагдуулж, хүүхэд өсвөр үеийн сэтгэл зүй, оюун санаа, хүмүүжил төлөвшилд сөргөөр нөлөөлж байна.

Архины шалтгаант эмгэг өөрчлөлт, архинд донтох өвчтэй буюу байнга хэтрүүлэн хэрэглэж удаа дараа эрүүлжигдсэн иргэдийн тоо тогтмол буурахгүй байгаа нь архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх, эмчлэгдсэн иргэнийг нийгэмшүүлэх, зорилтот бүлэгт чиглэсэн дэмжих үйлчилгээг бий болгож хөгжүүлэхийг шаардаж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас явуулсан судалгаагаар олон нийтийн дунд архины хэрэглээ өндөр байгаа нь тогтоогдсон бөгөөд байгууллага хамт олноороо зохион байгуулалттай, нийтийг хамарсан уралдаан тэмцээн аливаа арга хэмжээний үеэр согтууруулах ундаа хэрэглэх нөхцөл бололцоог бүрдүүлэх, ажлын байр, албан томилолтоор ажиллаж байхдаа согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зохисгүй хэв маягаас татгалзах шаардлага амьдралаас урган гарч байна.

Архинд донтох өвчтэй болон архидан согтуурч байгаа иргэдийн дийлэнх нь ажил хөдөлмөрийн өндөр бүтээмжтэй насны иргэд байгаа нь аймгийн хөгжил дэвшилд ихээхэн нөлөөлөх хүч боломж, хөдөлмөрийн нөөцийн алдагдлыг бий болгож байна.

Иймд аймгийнхаа хөгжил дэвшил, хүн ардынхаа эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХУГАЦАА

2.1.Хөтөлбөрийн зорилго

Нийгэм, гэр бүл, хамт олны дунд архины хэрэглээг бууруулах замаар эрүүл аюулгүй орчин бүрдүүлж, эрүүл чийрэг, ажилтай орлоготой, амар тайван Булганчуудыг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2.Хөтөлбөрийн зорилт

2.2.1.“Архигүй Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч, шийдвэр гаргах түвшний хүмүүс болон төрийн байгууллагуудын манлайллыг хөгжүүлэх

2.2.2. Архидан согтуурснаас эрүүл мэнд, гэр бүл, хамт олон нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаарх хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэн эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх.

2.2.3.Архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулж үр дүнг тооцох

2.2.4.Архины хамаарлаас гарсан, эмчлэгдэж эрүүлжигдсэн иргэдийг нийгэмшүүлэх, дэмжих үйлчилгээг хөгжүүлэх

2.2.5.Архидан согтуурснаас үүдэлтэй гэмт хэрэг, захиргааны зөрчил, золгүй учралын тохиолдлыг бууруулах, архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих хяналт, нийгмийн хариуцлагыг сайжруулах.

2.3.Хөтөлбөрийн хугацаа

Хөтөлбөрийг 2013-2016 он хүртэл хэрэгжүүлнэ.

ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТОД ХҮРЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛҮҮД

3.1.Нэгдүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.1.1.Архигүй Булган хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай шийдвэр зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх

3.1.2.Ёслол хүндэтгэлийн болон төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс аливаа арга хэмжээг архигүй зохион байгуулж хэвшүүлэх

3.1.2.Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг бүх нийтэд сурталчлах, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцож ажиллах

3.1.4. Архины асуудалтай иргэд, архинд донтох өвчтөний дэлгэрэнгүй болон архинаас үүдэлтэй эрүүл мэндийн хор хөнөөлийн талаарх судалгааг гаргах

3.1.5.Судалгааны үндсэн дээр архины асуудлаа шийдвэрлэх хүсэлтэй болон архинд донтох өвчтэй иргэдийг эрүүлжих хөтөлбөрт хамруулж зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.1.6.Архидан согтуурахаас үүдэлтэй эрүү, хэв журмын нөхцөл байдлын талаарх дэлгэрэнгүй судалгаа гаргаж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх

3.2.Хоёрдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.2.1.Уламжлалт зан үйлд тулгуурлан хүүхэд өсвөр үеийнхний дунд архины хор хөнөөлийн талаар ухуулан тайлбарлах, өөрийгөө хайрлах, хамгаалах амьдрах ухааны суурь боловсрол эзэмшүүлэх

3.2.2.Архинд донтох өвчний шалтгаан нөхцөл, хор хөнөөл, энэ төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг олон нийтэд зохион байгуулах

3.2.3.Архидан согтуурснаас үүдэлтэй эрүү хэв журмын нөхцөл байдалд үндэслэн урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

3.2.4.Бүх нийтээрээ, байгууллага хамт олноороо, гэр бүлээрээ архигүй орчин бүрдүүлэх хөдөлгөөн, санаачлага өрнүүлж, “Архины хэрэглээнээс татгалзсан” гэсэн тодотголтой сум,баг, байгууллага, хамт олон болон өрх гэр бүл, үйл ажиллагааг нийтэд сурталчлан хөгжүүлэх

3.2.5.Аливаа тэмдэглэлт өдөр, баяр ёслолыг архигүй тэмдэглэн өнгөрүүлэх хөдөлгөөн өрнүүлж, залуучуудын чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх тааламжтай орчинг бүрдүүлж, дэмжих

3.2.6.Архигүй орчин бүрдүүлсэн байгууллага хамт олон, өрх гэр бүл, иргэдийн тухай болон архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр зохион байгуулсан аливаа үйл ажиллагааг бүх нийтэд сурталчлан мэдээллэхэд хэвлэл мэдээллийн байгууллагууд санаачлагатай оролцож, дэмжиж ажиллах

3.2.7.Архины шалтгаант өвчлөл, эмгэг өөрчлөлтийн талаарх судалгаа, мэдээллийн сан бүрдүүлж, түүнд үндэслэсэн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг зохион байгуулах

3.2.8.Иргэдийн хандлагыг өөрчлөх, зорилтот бүлэгт чиглэсэн эрүүл зөв амьдрах чиглэлээрлекц, сургалт, уулзалт ярилцлага зохион байгуулах

3.2.9.Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, хэрэглээний талаар нийт хүн амын мэдлэгийг дээшлүүлэх талаар сургалт зохион байгуулах

3.3.Гуравдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.3.1.Архинд донтох өвчнийг эрт илрүүлэх зорилгоор холбогдох мэргэжлийн байгууллагууд тогтмол мэдээлэл солилцож хамтран ажиллах

3.3.2.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийн чадавхийг дэмжиж, тохиолдол бүр дээр холбогдох этгээдийг эрүүлжүүлэх, эмчлэх, соён гэгээрүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд татан оролцуулах

3.3.3.Хүсэлтээ гаргасан, гэрээ байгуулсан иргэдийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын сургалт, эмчилгээнд хамруулах

3.3.4.Архинд донтох өвчтэй иргэдийг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн албадан эмчилгээнд хамруулах, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх

3.3.5.Архинд донтох өвчтэй болон архины асуудалтай иргэдэд чиглэсэн сургалт нөлөөллийн цогц арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх

3.3.6.Сумын болон сургуулийн нийгмийн ажилтнуудыг аддиктологийн /архины асуудалтай иргэдэд үзүүлэх нийгмийн ажил/ чиглэлээр мэргэшүүлж, зорилтот бүлэгтэй тогтвортой ажиллах мэдлэг чадвартай болгож хөгжүүлэх

3.4.Дөрөвдүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.4.1.Сургалт, эмчилгээнд хамрагдаж архины асуудлаа шийдвэрлэсэн иргэдийг аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Мэргэжил сургалт үйлдэрлэлийн төв болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн материаллаг баазад түшиглэн мэргэжил олгох сургалтанд хамруулах

3.4.2.Хөдөлмөрийн хэлтэст ажил олгогчоосирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу архины асуудлаа шийдвэрлэсэн иргэдийг ажилд зуучлах, хөнгөлттэй зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах

3.4.3.Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн ажлын байрны судалгааг жил бүр нэгтгэн гаргах

3.4.4.Зорилтот бүлэгт чиглэсэн төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж клубуудыг бий болгож хөгжүүлэх

3.4.5.Зорилтот бүлэгт чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлж, гэр бүл, хамт олон, найз нөхдийн орчинд нь чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх

3.5.Тавдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.5.1.Архидан согтуурч захиргааны зөрчил гаргасан иргэдийг хяналтанд авч архины хэрэглээнээс татгалзах сэдэл төрүүлэх, зан үйлд сургах сургалт, нөлөөллийн ажилд хамруулах

3.5.2.Архидан согтуурсан иргэн, архи хэрэглэх нөхцөл бололцоог зохион байгуулалттай бүрдүүлсэн байгууллагын удирдлагад арга хэмжээ авч, зөрчил дутагдал, нөхцөл байдлыг арилгах албан мэдэгдэл, шаардлага хүргүүлж хэрэгжилтийг тооцох

3.5.3.Архи согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, зөрчил бүрт хариуцлага тооцож ажиллах

3.5.4.Архины хууль бус зар сурталчилгаанд тавих хяналтыг сайжруулж хууль тогтоомж, стандарт зөрчиж худалдаа үйлчилгээ явуулсан, сурталчилгаа хийсэн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авах

3.5.5.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах тусгай болон нэмэлт шаардлагын хэрэгжилтийг хянах, албан шаардлага хүргүүлж, хариуцлага тооцох

3.5.6.Согтууруулах ундааны хууль бус худалдаа үйлчилгээ, хэрэглээний хязгаарлалтанд тавигдсан хяналтыг сайжруулж, таслан зогсоох арга хэмжээ авах

ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1.Аймгийн ИТХ, Засаг дарга

4.1.1.Архигүй Булган хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг жил бүр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар, хоёр жилд нэг удаа аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж дүгнэлт өгөх

4.1.2.Архигүй Булган хөтөлбөрийг хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааны санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусган баталж, хэрэгжилт, үр дүнгийн мэдээллийг хэлэлцэж үнэлгээ дүгнэлт өгөх

4.1.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүр төлөвлөж хэрэгжилтийг хянах, энэ чиглэлээр батлагдсан шийдвэрүүдийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийж сайжруулах чиглэл, удирдлагаар хангах

4.1.4.Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, үнэлгээ дүгнэлт хийж, сайжруулах арга хэмжээ авах

4.1.5.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, энэ төрлийн худалдаа үйлчилгээний журам, стандарт зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож, үр дүнг мэдээллэх

4.2.Сумын ИТХ, Засаг дарга

4.2.1.Архигүй Булган хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулах

4.2.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах төсөв хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэх

4.2.3.Хөтөлбөрийн хэрэгжилт, явц үр дүнг жил бүр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал, хоёр жил тутам сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж дүгнэлт өгөх, сайжруулах арга хэмжээ авах

4.2.4.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, энэ төрлийн худалдаа үйлчилгээний журам, стандарт зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож, үр дүнг мэдээллэх

4.2.5.Сум бүр аддиктологийн чиглэлээр мэргэшисэн ажилтантай болж зорилтот бүлэгт хандсан нийгмийн ажлыг тогтвортой зохион байгуулах, тэдний гэр бүл, хамт олон, найз нөхдөд чиглэсэн сургалт нөлөөллийн ажил хийх

4.2.6.Зорилтот бүлгийн иргэдийг мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөрөө хорших, ажил хөдөлмөр, аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжиж, төсөл хөтөлбөрт хамруулах, ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлэх

4.2.7.Иргэдэд архины хор хөнөөлийг ухуулан таниулах, уламжлалт зан үйлд тулгаарлан архигүй баярлах зан үйлийг түгээн дэлгэрүүлэх, эрүүл гэр бүлийн орчинг бүрдүүлэхэд дэмжих

4.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

4.3.1.Архидан согтуурах явдлын шалтгаан нөхцөлийн судалгаа хийж, судалгаанд үндэслэн сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах

4.3.2.Зорилтот бүлэгт чиглэсэн эмчилгээ, сэтгэл зүйн болон нийгэмшүүлэхэд холбон зуучлах үйлчилгээг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусган мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх

4.3.3.Эмчилгээ, сэтгэл зүйн болон нийгэмшүүлэхэд холбон зуучлах үйлчилгээний үр дүнг судалж, цаашид анхаарах зөвлөмж чиглэлийг боловсруулж хүргүүлэх

4.3.4.Архидан согтуурсны улмаас үйлдэгдсэн эрүү хэв журмын нөхцөл байдал, золгүй учрал, өвчлөлийн талаарх судалгаа дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулах, нийтэд мэдээллэх, сэрэмжлүүлэх

4.3.5.Архины хэрэглээнээс татгалзсангэр бүл, хамт олон, сум, баг, гудамж хорооллыг олон нийтэд сурталчлах, архины хэрэглээнээс татгалзах бүх нийтийн хөдөлгөөн, санаалчлагыг өрнүүлэх

4.4.Төрийн байгууллагууд

4.4.1.Байгууллагын дотоодод болон үйл ажиллагааны хамрах хүрээгээр архигүй орчин бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4.4.2.Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн иргэнийг нэвтрүүлэхгүй байх, ажлын байранд болон албан томилолтоор ажиллах хугацаандаа сахилгын зөрчил гаргасан ажилтан, албан хаагчдад хариуцлага тооцож ажиллах

4.4.3.Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн гэрээнд энэ төрлийн сахилгын зөрчил гаргавал оногдуулах хариуцлагыг тодорхой тусган хувь хүний үүрэг хариуцлага, сахилга батыг өндөржүүлэх

4.4.4.Иргэд олон нийт, төрийн бус байгууллагаас гаргасан үүсгэл санаачлагыг дэмжиж, архины хор хөнөөлийн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил арга хэмжээнд байгууллага, хамт олноо оролцуулах

4.5.Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага

4.5.1.Архигүй Булган хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, бүх нийтийг уриалах, манлайлан оролцох

4.5.2.Архины хамааралтай болон архинд донтох өвчтэй иргэдэд сэтгэл зүйн болон нийгмийн ажил үйлчилгээг үзүүлэх

4.5.3.Аддиктологийн нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлж, бусад нийгмийн ажилтнуудыг энэ чиглэлээр мэргэшихэд дэмжлэг үзүүлэх

4.5.4.Аж ахуйн нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагаа нэмэгдүүлж архидан согтуурахын эсрэг сургалт соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах

4.5.5.Байгууллагын дотоодод болон үйл ажиллагааны хүрээгээр архигүй орчинг бүрдүүлж, зохион байгуулалтын аливаа арга хэмжээнд согтууруулах ундаа хэрэглэхээс татгалзах бүх нийтийн хөдөлгөөн, уриалгад нэгдэх

4.5.6.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, холбодох журам, стандартыг мөрдөж ажиллах

4.5.7.Архи согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгчид стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах

4.6.Хэвлэл мэдээллийн байгууллага

4.6.1.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, журмыг нийтэд сурталчлах, архины нийгэм ахуйн болон эрүүл мэндийн хор хөнөөлийг тайлбарлан таниулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох

4.6.2.Архины хэрэглээгүй орчин бүрдүүлсэн гэр бүл, байгууллага, хамт олон, баг хороо, сумыг нийтэд сурталчлах

4.6.3.Архигүй Булган хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг бэлтгэн холбогдох байгууллагатай хамтран ажиллах, бүх нийтийг уриалсан, олон нийтийг хамарсан хөдөлгөөн санаачлагыг дэмжиж хамтран ажиллах

4.6.4.Энэ төрлийн сургалт сурталчилгаа, мэдээллийг явуулахад зориулж тусгай хөтөлбөр, мэдээллийн цагтай байх

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

5.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь олон улсын төсөл хөтөлбөр, улсын болон орон нутгийн төсвийн дэмжлэгээс бүрдэнэ.

5.2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамжаар орон нутгийн төсөвт төвлөрсөн хөрөнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээгээр төлөвлөж Архидан согтуурахтай тэмцэх урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

ЗУРГАА .ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

6.1. Хүрэх үр дүн

6.1.1.Төрийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуй нэгж болон өрх гэр бүл, иргэнд архигүй эрүүл орчин бүрдсэн байна.

6.1.2.Олон нийт архины хор хөнөөлийн талаарх мэдлэгтэй болж, олон нийтийн дунд эрүүл зөв амьдрах хандлага нэмэгдсэн байна.

6.1.3.Архинд донтох өвчлөл буурч, эмчлэн эдгэрүүлсэн архины асуудлаа шийдвэрлэж өөрчлөгдсөн иргэдийн тоо жил тутам өссөн байна.

6.1.4.Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин тодорхой хувиар өсч өрхийн орлого нэмэгдсэнээр ажилгүйдэл ядуурал гэсэн нийгмийн сөрөг үзэгдлүүд буурна.

6.1.5.Архидан согтуурсан гэмт хэрэг зөрчлийн гаралт буурч, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл сайжирсан байна.

6.2.Үр дүнг үнэлэх үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн			
		2013	2014	2015	2016
Зорилт 1.Удирдлага зохион байгуулалтаар хангах, шийдвэр гаргах түвшиний хүмүүс, төрийн байгууллагуудын манлайллыг хөгжүүлэх					
1.1	Эрүүл аюулгүй орчин бүрдүүлсэн төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагын эзлэх хувь	25%	40%	50%	60%
1.2	Эрх зүйн орчин бүрдүүлж хариуцлага тооцож хэвшсэн төсөвт болон аж ахуйн нэгж байгууллагын эзлэх хувь	25%	50%	75%	100%
Зорилт 2. Архидан согтуурснаас эрүүл мэнд, гэр бүл, хамт олон нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаар хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэн эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлнэ.					
2.1	Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг төсөвт болон аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын тоо нэмэгдсэн байдал	25%	40%	50%	60%
Зорилт 3. Архины хамаарал болон архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулж үр дүнг тооцох					
3.1	Архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн өсөлт	5%	10%	15%	20%
3.2.	Архины асуудалтай иргэдэд үзүүлсэн нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийн өсөлт	5%	10%	15%	20%
Зорилт 4. Архины хамаарлаас гарах, эмчлэгдэж эрүүлжигдсэн иргэдийг нийгэмшүүлэх, дэмжих үйлчилгээг хөгжүүлэх					
4.1	Архины хамаарлаас гарсан, эмчлэгдэж эрүүлжигдсэн иргэдийг мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулах	5%	10%	15%	20%
4.2	Зорилтот бүлгийн иргэдийг ажлын байраар хангах, байнгийн болон түр ажлын байранд зуучлах, нийтийг хамарсан ажилд оролцуулах	5%	10%	15%	20%
Зорилт 5. Архидан согтуурсанаас үүдэлтэй гэмт хэрэг, захиргааны зөрчил, золгүй явдалын тохиолдлыг бууруулах, архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих хяналт, нийгмийн хариуцлагыг сайжруулна.					
5.1	Эрүүлжүүлэгдсэн хүний тоо бууралт хувиар/өмнөх оны үр дүнтэй харьцуулсан бууралтын хувь/	5%	5%	5%	5%

5.2	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн бууралт нийт гэмт хэрэгт эзлэх хувиар	3%	3%	3%	3%
5.3	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн өмнөх онтой харьцуулсан бууралт/нийт зөрчилд эзлэх хувиар/	5%	5%	5%	5%

6.3.Тайлагнах, дүгнэх

6.2.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын тайланг хагас жилээр 6 сарын 15,бүтэн жилээр 12 дугаар сарын15 –ныдотор хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэгт ирүүлнэ.

6.2.2.Аймгийн ажлын хэсэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлын дүнг нэгтгэн дүгнэж Засаг даргын Зөвлөлийн хуралд жил бүр, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хоёр жил тутам танилцуулж байна.

АЖЛЫН ХЭСЭГ

“АРХИГҮЙ БУЛГАН” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт				Хариуцах эзэн	Хамтран ажиллах байгууллага
		Хугацаа	Тоо хэмжээ	Хүрэх үр дүн	Төсөв		
Зорилт 1. Удирдлага зохион байгуулалтаар хангах, шийдвэр гаргах түвшний хүмүүс, төрийн байгууллагуудын манлайллыг хөгжүүлэх							
1.1.	“Архигүй Булган” хөтөлбөрийн ажлын хэсгийг байгуулж, хөтөлбөрийн хүрээнд хийх ажлын чиглэлийг талуудад үүрэг даалгавар болгож хүргүүлэх	2013-2016	1 удаа	Тухайн жилд хийх ажил, хүрэн үр дүнг тодорхойлсон байна.	-	ХЗХ	ГХУСАЗЗөвлөл
1.2.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт өгөх	2013-2016	Жилд 2 удаа	Тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн байна.	-	ХЗХ	ГХУСАЗЗөвлөл
1.3.	Архигүй орчин бүрдүүлэх, Архидан согтуурахтай тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр шийдвэр гаргаж, холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгөх	2013	Тухай бүр	Архидан согтуурсан зөрчил буурна.	-	ТЗУХ Г.Бадамсүрэн	Төрийн албаны салбар зөвлөл
1.4	Төрийн жинхэнэ албан хаагчдын ёс зүйн дүрэм, байгууллагын ёс зүйн хэм хэмжээ, хөдөлмөрийн дотоод журамд согтууруулах	2013-2016	1	Төрийн байгууллагуудад архи хэрэглэх сахилгын зөрчилгүй	-	ТЗУХ Г.Бадамсүрэн	Төрийн албаны салбар зөвлөл, сум, байгууллаг

	ундаа хэрэглэсэн сахилга, ёс зүйн зөрчил гаргавал хариуцлага тооцож ажиллах нөхцлийг бүрдүүлсэн нэмэлт өөрчлөлт, зохицуулалт оруулах			болно.		эн	ын удрдлагууд
1.5.	Төр, төсвийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд архи согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчлийг хөдөлмөрийн гэрээг цуцлах ноцтой зөрчилд тооцох талаар нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэгжүүлэн, ажилтан албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх	2013-2016		Ажилтнуудын сахилга хариуцлага нэмэгдэнэ.		ТЗУХ	Төр, төсвийн байгууллагын удирдлагууд
1.6	Аж ахуйн нэгж, байгууллага бүр ажлын байрандаа “Архигүй орчин”, “Архидалтгүй хамт олон” гэсэн тэмдэг, уриаг олон нийтэд байрлуулах, бусдыг үлгэрлэн ажлыг зохион байгуулах	2013-2016	Жил бүр	Олон нийтийн санаачлага өрнөсөн байна		Хөгжлийн бодлогын хэлтэс	Сумын Засаг дарга
1.7	Архины асуудалтай иргэд, архинд донтох өвчтөний дэлгэрэнгүй судалгааг гаргах	2013-2016	Жил тутам тодотгоно	Зорилтот бүлэг тодорхой болсон байна.	ОН-ын төсөв	Цагдаагийн хэлтэс	ГХУСАЗЗ, ЭМГ, Сум, багийн Засаг дарга нар
1.8	Архинд донтох өвчний хор хөнөөлийн талаахи судалгааг гаргах	2013-2016	Жил тутам тодотгоно	Нийгмийн аюулын цар хүрээ тодорхой болно	Улсын төсөв	Эрүүл мэндийн газар	Нэгдсэн эмнэлэг, сум, сумдын эмнэлэг, баг, өрхийн

							эмнэлэг
1.9	Архидан согтуурснаас үүдэлтэй эрүүгийн гэмт хэрэг, захиргааны зөрчил, золгүй учралын шалтгаан нөхцлийг судалгааг гаргах	2013-2016	Жил бүр тодотго но	Урьдчилан сэргийлэх арга зам боловсруулах нөхцөл бүрдэнэ.	ОН-ын төсөв	Цагдаагийн хэлтэс	ГХУСАЗЗ ХЗХ
1.10	Архинд донтох өвчнийг эмчлэх хордлого тайлах болон сайн дурын эмчилгээний үр нөлөөг судалж, үр дүнг тооцох	2013-2016	1 удаа	Хэрэгжүүлсэн ажлын үр нөлөө тооцсон байна.	-	ГХУСАЗЗ	ХЗХ
1.11	Судалгаанд үндэслэн зорилтот бүлэгт чиглэсэн архинаас гаргах сургалт нөлөөллийн ажил, архинд донтох өвчнийг эмчлэх цогц эмчилгээ, дэмжих чиглэлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	2013-2016	Тухай бүр	Тодорхой ажил арга хэмжээ хэрэгжиж жил бүр 10 хүнийг эрүүлжүүлсэн байна.	Төсөл, төсөв	ГХУСАЗЗ	ХЗХ
1.12	Архины асуудлаа шийдвэрлэсэн гэр бүл, иргэдийг шалгаруулж урамшуулдаг тогтолцоо бүрдүүлэх	2013-2016	4 удаа	Иргэн, өрх бүрийн санаачлага идэвхи оролцоо хөгжинө	2,0 сая	Аймгийн ЗД	Сумын ЗД, ГХУСАЗЗ ХЗХ
1.13	Сэтгэц наркологийн тасгийг өргтгөж, хорт зуршлын эмнэлзүйн кабинетийг байгуулах	2014-2016	17	Эмчилгээ, судалгааны материаллаг бааз бүрдэнэ		Эрүүл мэндийн газар	Сумын ЗД, Нэгдсэн эмнэлэг
Зорилт 2. Архидан согтуурснаас эрүүл мэнд, гэр бүл, хамт олон нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаар хүн амын мэдлэг, хандлагыг дээшлүүлэн эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлнэ.							
2.1	Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд “Архинд донтох өвчний шалтгаан, хор хөнөөл,	2013-2016	Сар бүр	Энэ төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх	-	Эрүүл мэндийн газар	Нэгдсэн эмнэлэг, ТББайгуул

	түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сургалт, сурталчилгааны хөтөлбөр, гарын авлага материал боловсруулж -байгууллага -аж ахуйн нэгж -сум -багт зохион байгуулна.			мэдлэгтэй болно			лага
2.2	Хорт зуршлын хор уршиг, түүнээс өөрийгөө болон найз нөхдөө хамгаалах арга зам, урьдчилан сэргийлэх, амьдралын эрүүл, зөв дадал хэвшил, ёс суртахууны тухай сургалт сурталчилгааны материал бэлтгэн хүүхэд, өсвөр үеийнхэнд сурталчлах	2013-2016	Сар бүр	Өсвөр үеийнхэн хорт зуршлын тухай мэдлэгтэй болж УС арга замыг эзэмшинэ.	-	Боловсрол соёлын газар Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс	ЭМ-ын газар, Цагдаагийн хэлтэс Бүх шатны Сургууль, цэцэрлэг
2.3	Сургууль цэцэрлэгийн орчиныг “Хорт зуршилгүй-Эрүүл орчин” болгох зорилгоор хүүхдийн оролцоо, эцэг эхийн зөвлөлийн оролцоо, сургууль, цэцэрлэгийн захиргааны оролцоог хангасан арга хэмжээг зохион байгуулах	2013-2016	Тухай бүр	Эцэг эхийн оролцоо сайжирч, хамтарч ажиллах, хичээнгүй байдал хангагдана		БСГазар Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс	Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс Бүх шатны сургууль, цэцэрлэг, Сум, багийн ЗД нар
2.4	Хорт зуршлын хор хөнөөлийг нийтэд ойлгуулах, зөв хандлага дадал олгох зорилгоор танин мэдэхүйн тэмцээн, уралдаан зохион байгуулах, нийтлэл нэвтрүүлгийн	2013-2016	4 сард	Өсвөр үеийн мэдлэг дээшилнэ	1,0 сая	ГХУСАЗЗ Хэвлэл мэдээллийн байгууллага	ЕБС-иуд, сумын ЗД нар, Булган сумын Соёлын төв

	хөтөлбөрөөр олон нийтэд сурталчлах						
2.5	“Хүүхдийн зуслан-Хүүхдэд ээлтэй орчин” сургалт нөлөөллийн ажлийг зохион байгуулах	Жил бүр	6-8 сард	Өсвөр үеийнхэн хорт зуршлын тухай ойлголт зөв хандлагатай болсон байна.		Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс	ГХУСАЗЗ БСГазар, ЦХэлтэс, ЭМГазар
2.6	“АРХИГҮЙ” хамт олон, байгууллага, хувь хүмүүс, өрх гэр, баг, хороо, сумыг шалгаруулан нийтэд сурталчилна	Жил бүр	Жилд 1 удаа	Жил бүр 10 байгууллага, хувь хүн шалгарсан байна.		Хууль зүйн хэлтэс	Сумын ЗД нар, Салбар ГХУСАЗЗ, ТББ,
2.7	Нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрүүдийг уламжилалт зан үйлд тулгуурлан архигүй баярлах, бүтээлчхэв маягыг хэвшүүлэх	Тухай бүр	Жилдэ э	Соёлтой зөв орчин, бүтээлч уур амьсгал бүрдэнэ.		Аймаг, сумын ЗД	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж
2.8	“Архи хэрэглэхгүй байх” уриалгыг олон нийт, гэр бүлд уриалж, байгууллага аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд манлайллан оролцох	2013-2016	Жилдэ э	Нийгмийн хандлага өөрчлөгдсөн байна.		Аймаг, сумын ЗД	Аймаг, сумын ИТХ, байгууллага, аж ахуйн нэгжүүд
2.9	Шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад архинд донтох өвчний ойлголт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний сургалт	2013	1 удаа	Шийдвэр гаргагчдын ойлголт хандлага өөрчлөгдөнө	0,5 сая	ХЗХ	ЭМГазар ТББ

2.10	Архигүй Булган хөтөлбөрийн уриалга, санамж, сэрэмжлүүлэг материалыг хэвлүүлж нийтэд тараах	2013	Байгууллага, өрхийн тоо	Архигүй Булган хөтөлбөрийн мэдээлэл тарсан байна	3,0 сая	Аймгийн ЗДТГ-НҮАлба	Сумын Засаг дарга нар
2.11	Олон нийтийг хамарсан “Хорт зуршилгүй байх” аян өрнүүлж, тайлагнах	2013-2016	4 удаа	Олон нийтийн оролцоо нэмэгдсэн байна		Эрүүл мэндийн газар	Сумын ЗД нар

Зорилт 3. Архины хамаарал болон архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулж үр дүнг тооцох

3.1	Мэргэжлийн байгууллагын судалгаанд үндэслэн зорилтот бүлгээ тодорхойлж, уузалт ярилцлага зохион байгуулах	Жил бүр	2	10 иргэн, гэр бүл архины хамаарлаас гарсан байна.	ОН-ын төсөв, төсөл хөтөлбөр,	Аймаг, сумын ЗДарга	ГХУСАЗЗ ЭМГазар, Нэгдсэн эмнэлэг, ЦХэлтэс
3.2	Зорилтот бүлгийг сэтгэл засал, хордлого тайлах эмчилгээнд хамруулах	Жил бүр	10	50-иас доошгүй өрх хамрагдсан байна.	10,0 сая	Аймаг, сумын ЗД	Нэгдсэн эмнэлэг, ТББ
3.3	Сум, сургуулиудад аддиктологийн/архины асуудалтай иргэдэд үзүүлэн нийгэм, сэтгэлзүйн үйлчилгээ/чиглэлээр мэргэшүүлж, арга зүйн удирдлагаар хангах	Жил бүр	30	Аддиктологийн чиглэлээр мэргэшсэн байна.	6,4 сая	Сумын ЗД нар, БСГазар	Сумдын Салбар зөвлөл, ЕБС
3.4	Зорилтот бүлэгт чиглэсэн албадан эмчилгээнд хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах	Жил бүр	10	Жил бүр 5-10 хүртэл хүн хамрагдана	1,2 сая	Цагдаагийн хэлтэс	Нэгдсэн эмнэлэг ТББ
3.5	Архинд донтох өвчтэй, архины асуудлаа	Жил бүр	Жилийн турш	Тасралтгүй зохион			ГХУСАЗЗ Мэргэжлийн

	шийдвэрлэсэн иргэдэд сургалт нөлөөллийн арга хэмжээг цогцоор зохион байгуулах			байгуулагд аж хэвшсэн байна.		ТББгууд	н байгууллага
--	---	--	--	------------------------------	--	---------	---------------

Зорилт 4. Архины хамаарлаас гарах, эмчлэгдэж эрүүлжигдсэн иргэдийг нийгэмшүүлэх, дэмжих үйлчилгээг хөгжүүлэх

4.1	Архины асуудлаа шийдсэн, эмчлэгдэж эрүүлжигдсэн иргэдийг мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулах	Жил бүр		Мэргэжилтэй болсон байна.		Сумын Засаг дарга нарт	Хөдөлмөрийн хэлтэс, НХХ, МСҮТ
4.2	Зорилтот бүлгийн иргэдийг ажлын байраар хангах, байнгийн болон түр ажлын байранд зуучлах, нийтийг хамарсан ажилд оролцуулах	Жил бүр		Ажилтай, орлоготой болсон байна.		Сумын ЗД нар	Хөдөлмөрийн хэлтэс
4.3	Зорилтот бүлгийн иргэдийг амьдрах ухааны сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамруулах	Тухай бүр		Зан үйл, дадал хэвшил, сэтгэлгээ өөрчлөгдөнө		Сумын ЗД нар	ТББгууд
4.4	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх бололцоог өргөтгөх, олон улсын төсөл хөтөлбөрт хамруулахад дэмжих	Тухай бүр		Ажилтай, орлоготой байх боломж бүрдэнэ		Сумын ЗД нар	ТББГууд, Хөдөлмөрийн хэлтэс

Зорилт 5. Архидан согтуурсанаас үүдэлтэй гэмт хэрэг, захиргааны зөрчил, золгүй явдалын тохиолдлыг бууруулах, архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих хяналт, нийгмийн хариуцлагыг сайжруулна.

5.1	Архидан согтуурсан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах	2013	17	Сум бүрт хийгдсэн байна.	1,0 сая	Сумын ЗД нар	ГХУСАЗЗ
-----	--	------	----	--------------------------	---------	--------------	---------

5.2	Архидан согтуурсан гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулах албан мэдэгдэл, шаардага хүргүүлэх	Тухай бүр		Шалтгаан нөхцөл арилсан байна.		Цагдаагийн хэлтэс	Хуулийн байгууллагууд
5.3	Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шаардлага, албан мэдэгдлийн мөрөөр урьдчилан сэргийлэх болон шалтгаан нөхцлийг арилгах арга хэмжээ зохион байгуулж хариу мэдэгдэх	Тухай бүр		Тодорхой ажил хийгдсэн байна.		Сумын ЗД нар	Байгууллагын дарга нар
5.4	Архидан согтуурахтай тэмцэхтухай хууль аймгийн ИТХ-аас батлагдсан журам, дүрмүүдийг сурталчлах, хэрэгжилтийг хянан шалгах	2013-2016	Жил бүр	Шалгалт тогтмол үр дүнтэй хийгдсэн байна.		Хөгжлийн бодлогын хэлтэс	ЦХ, МХГ, СХХ, Сумын ЗД
5.5	Тусгай зөвшөөрөл бүхий худалдаа үйлчилгээний цэгүүдийн жил бүр аттестатчилах	Жил бүр		Жил бүр шалгагдсан байна.		Хөгжлийн бодлогын хэлтэс	Сумын ЗД нар, СХХ,
5.6	Архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд сургалт сурталчилгаа хийх	2013-2016	Жил бүр	Сургалт тогтмол хийгдсэн байна.	1,0 сая	Хууль зүйн хэлтэс	Сумын ЗД Мэргэжлийн хяналтын газар
5.7	Архидан согтуурсан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нэгбүрчилсэн болон тусгай арга хэмжээ зохион байгуулж, удирдамж төлөвлөгөөг	Тухай бүр	4	Тодорхой ажил зохион байгуулагдсан байна.		Цагдаагийн хэлтэс	ГХУСАЗЗ Сумын ЗД нар

	боловсруулах						
5.8	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдах, эрх нь хасагдсан жолооч нарт зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг хийх	Тухай бүр		Сум бүр драгертай болсон байна. Согт уугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил давтан гарахгүй байх	4,0 сая	Сумын ЗД нар	Цагдаагийн хэлтэс
5.9.	Архи согтууруулах ундааны хууль бус худалдаа, үйлчилгээнд тавих хяналт, хариуцлагыг сайжруулж хариуцлага тооцох	2013-2016	Тухай бүр	Хууль бус худалдаа эрхлэгчидийг илрүүлэн шийдсэн байна		Цагдаагийн хэлтэс	Сумын ЗД нар

